

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ
АУДИТЫН КОД: БНА-2025/07-3-ШТА-НА

Баянхонгор хот 2025 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**
Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 80112188 цахим хуудас: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Батчимэг
Утас: 91113253 цахим хуудас: batchimegn@audit.gov.mn
Аудитын багийн гишүүд

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	5
ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ	9
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА.....	9
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ.....	10
НЭГ. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ	10
ХОЁР. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛЖ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ	12
ДҮГНЭЛТ	16
ЗӨВЛӨМЖ	17
ХАВСРАЛТ	17



Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Хөдөө аж ахуй
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний үзүүлэлт	5
Хүснэгт 2	Аймгийн аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл	5
Хүснэгт 3	Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн	6
Хүснэгт 4	Хүний нөөц	7
Хүснэгт 5	Иргэдийн орлого	7
Хүснэгт 6	Хөдөө аж ахуйн нөөц	7
Хүснэгт 7	Төсвийн 2020-2024 оны гүйцэтгэл	8
Хүснэгт 8	Төсвийн тухай хуулийн шаардлага	10

Графикийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн	6
График 2	Инфляцын түвшин (хувь), хэрэглээний үнийн индексийн өсөлт (коэф)	6



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл”, түүнчлэн аймгийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэсэн заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн “Санхүүгийн тайлангийн аудитын шалгагдагч байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” А/86 дугаар тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/02 дугаар тушаалыг үндэслэн аудит хийв.

Аудитын зорилт

Баянхонгор аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогыг бүрэн төлөвлөсөн эсэх
- ✓ Төсвийн зарлагыг арвилан хэмнэлттэй, үр нөлөөтэйгөөр төлөвлөсөн эсэх
- ✓ Төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх

Аудитыг хамарсан хүрээ

Баянхонгор аймгийн Засаг даргаас Сангийн яаманд өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Татварын газар, ГХБХБГ, ОНӨГ зэрэг бусад шалгагдагч болон хамрагдагч этгээдээс ирүүлсэн холбогдох бусад баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудитын MNS6817:2020 Монгол Улсын стандарт, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, МУЕА-ын 2022.08.17-ны өдрийн А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” зэрэг аудитыг чиглүүлж гарсан бусад заавар, аргачлалыг мөрдөн, аудитад шалгагдагч болон хамрагдагч байгууллагын газар нэгжүүдийн холбогдох албан тушаалтнуудаас нэмэлт тодруулга, лавлагаа, судалгааг авч, ярилцлага хийх, аудитын явцад цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлж нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт өгч байна.



**Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- ✓ Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж
- ✓ Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер М.Алтантуяа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, Б.Азбаяр, Н.Батчимэг, аудитор Н.Бүнчинсүрэн, Д.Цэдэвцэвээн, Д.Даваадорж, Г.Энхзул, А.Адилзаяа, Д.Оюун-Эрдэнэ нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр батлуулж, талбарын ажлыг гүйцэтгэж, орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн үр ашгийг сайжруулах дүгнэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн ИТХ-д хүргүүлэв.



ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-т зааснаар Баянхонгор аймгийн Засаг даргын 2026 оны орон нутгийн төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасны дагуу дүгнэлт гаргав.

Баянхонгор аймгийн Засаг даргаас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3¹-т заасан цаглавар хугацаанд 2026 оны орон нутгийн төсвийн төслийн нийт зарлагыг 101,102.0 сая төгрөгөөр, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс 63,173.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 37,920.8 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Улсын их хурал Сангийн яамны хянасан 37,920.8 сая төгрөгийн орлогыг 1,196.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт орлогыг 39,837.5 сая төгрөгөөр баталжээ. Үүнд орон нутгийн татварын орлогыг 37,422.8 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 45.0 сая, торгуулийн орлого 2,200.0 сая, хүүгийн орлого 54.7 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 115.0 сая төгрөгөөр баталсан байна.

“Баянхонгор аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”-нд 83,690.0 сая төгрөгийн 178 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бол 2026 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг төсвийн хэмнэлттэй уялдуулан бууруулах бодлого баримталж 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна².

Хүснэгт 1. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний үзүүлэлт

Он	Үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээний тоо	Үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээний мөнгөн дүн (сая.төг)
2025	178	83,690.0
2026	58	14,809.5

Эх сурвалж: Баянхонгор аймгийн 2025, 2026 оны хөгжлийн төлөвлөгөө

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН 2021-2024 ОНЫ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ:³

Хүснэгт 2. Аймгийн аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл (сая төгрөг)

Нийт үйлдвэрлэл	2021 он	2022 он	2023 он	2024 он
Уул уурхай, олборлолт	46,646.2	66,844.4	50,998.2	53,334.6
Боловсруулах үйлдвэрлэл	2,455.0	2,144.4	2,470.3	2,352.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7,072.0	6,695.3	10,847.4	13,769.7

¹ төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийгэд ил тод мэдээлэх

² Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс “Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг салбар, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн үр дүнгээр болон үйл ажиллагаа, төсөл арга хэмжээгээр үнэлж гэсэн үзүүлэлтээр дүгнэж 87.5 хувиар үнэлсэн байна. Харин Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгээр 50.5 хувьтай үнэлсэн байна.

³ Эх сурвалж- <https://data.nso.mn/?aimagid=64>



Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	2,162.5	2,663.1	2,556.4	3,735.1
Дүн	58,335.7	78,347.2	66,872.3	73,191.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн статистикийн хэлтсээс гаргасан 2024 оны аймгийн статистик мэдээ




График 1. Аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн

Хүснэгт 3. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн (сая төгрөг)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн /сая.төг/	572,563.0	349,988.7	541,283.9	743,803.1	757,573.7
Нэг хүнд ногдох ДНБ /сая.төг/	6457.3	3903.9	6027.1	8396.9	8613.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн статистикийн хэлтсээс гаргасан 2024 оны аймгийн статистик мэдээ




График 2. Инфляцын түвшин (хувь), хэрэглээний үнийн индексийн өсөлт (коэф)



Хүснэгт 4. Хүний нөөц

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Хүн амын тоо	89329	89975	89643	88499	88524
Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)	67.6	71.0	71.1	72.4	71.0
Ажиллагчдын тоо (мянган хүн)	40.8	35.5	39.2	38.5	43.0
Ажилгүйдлийн түвшин (хувь)	6.2	7.9	6.5	5.7	6.1
Малчдын тоо (мянган хүн)	23.2	23.1	22.6	21.9	21.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн статистикийн хэлтсээс гаргасан 2024 оны аймгийн статистик мэдээ

Хүснэгт 5. Иргэдийн орлого

(мянган төгрөг)

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин	863.3	912.0	1,024.5	1,353.2	1,906.8
Нэг өрхийн сарын дундаж орлого (бүсээр)	1,235.8	1,479.5	1,636.7	1,947.0	2,278.9
Нэг өрхийн сарын дундаж зарлага (бүсээр)	1,293.8	1,395.9	1,669.8	2,082.4	2,476.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн статистикийн хэлтсээс гаргасан 2024 оны аймгийн статистик мэдээ

Хүснэгт 6. Хөдөө аж ахуйн нөөц

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Малын тоо (сая толгой)	3.8	3.1	3.7	4.0	4.0
Тариалсан талбай (га)	586.0	724.9	612.7	516.1	538.6
ХАА-н салбарт оруулсан УТХО (сая.төг)		9,356.1	5,706.1	3,843.8	11,222.7

Тухайлбал: Шинэ хөдөө төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 2,708.9 сая.төгрөгийн 91 нэр төрлийн 847 ширхэг тоног төхөөрөмжийг аймаг, сумдад хүлээлгэн өгсөн байна.

Эх сурвалж: Баянхонгор аймгийн статистикийн хэлтсээс гаргасан 2024 оны аймгийн статистик мэдээ

Банк, санхүүгийн товч мэдээлэл: Баянхонгор аймгийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 68,881 хадгаламж эзэмшигч 173.3 тэрбум төгрөгийн хугацаатай, 44.9 тэрбум төгрөгийн хугацаагүй хадгаламжтай, 64,413 зээлдэгч 567.0 тэрбум төгрөгийн зээлтэйгээс анхаарлаа хандуулах зээл 10.5 тэрбум, чанаргүй зээл 11.9 тэрбум төгрөг байна.

Эрдэс баялгийн товч мэдээлэл: Зөвхөн олон нийтэд ил тод болсон мэдээллээс үзэхэд (Шинэжинстийн нүүрсний уурхайн мэдээлэл олдоогүй болно):

- Баруун бүсийн үнэт металл худалдан авах Монгол банкны салбар нь 2025 онд 1,532.8 кг алт худалдан авсан байна. (Эх сурвалж: Монгол банкны салбарын мэдээллээс)
- Эрдэнэ Монгол ХХК-ийн цахим хуудсанд нийтэлсэн нээлттэй мэдээлэлд 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр олборлох үйл ажиллагааг эхлүүлж, 342 унц алт, 96 унц мөнгө олборлосон, мөн жилд дунджаар 650.0 мянган тонн хүдэрийг боловсруулж, 85.0 мянган унц алт олборлох хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулсан гэж мэдээлсэн байна. Дээрх тоон мэдээллээс тооцож үзэхэд Монгол банкны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөрх 1 унц алтны



ханшаар АМНАТ-ыг тооцож үзэхэд ОНХС-д зөвхөн тухайн компаниас 18.5 тэрбум төгрөг хуваарилагдах тооцоо гарч байгаа бөгөөд ирэх жилүүдэд ААНОАТ-аас орон нутагт хуваарилагдах төсвийн орлого ахиуц хэмжээгээр нэмэгдэх эерэг төлөв харагдаж байна.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ:

Хүснэгт 7. Төсвийн 2020-2024 оны гүйцэтгэл

(сая төгрөг)

Үзүүлэлт		2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Орон нутгийн орлого	Төлөвлөгөө	13,272.8	13,826.6	16,617.2	20,190.1	32,158.4
	Гүйцэтгэл	14,953.1	17,281.0	21,685.3	23,644.6	38,202.0
	Биелэлт	112.7%	125.0%	130.5%	117.1%	118.7
Батлагдсан төсөв	Төлөвлөгөө	94,238.1	47,547.9	58,993.2	77,916.3	108,785.8
	Гүйцэтгэл	87,308.5	41,797.0	51,608.7	69,931.0	91,829.2
	Биелэлт	92.6%	87.9%	87.5%	89.8%	84.4%
Санхүүгийн дэмжлэг	Гүйцэтгэл	18,764.2	17,503.5	17,677.9	23,195.8	34,182.5
Аудитын зөвлөмжийн хэрэгжилт						
Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудит		70.5%	83.3%	80.6%	71.3%	87.1%
Хоршоо хөгжүүлэх сан	Сан	5,114.6	5,174.1	5,240.6	5,297.9	5,385.0
	Зээлийн авлага	3,636.8	2,581.3	4,094.5	3,913.6	3,536.6
	Мөнгөн үлдэгдэл	1,477.8	2,592.8	1,146.1	1,384.3	1,848.4
	Төлөвлөгөө	1,499.0	2,385.0	3,970.3	2,409.4	1,589.3
	Гүйцэтгэл	954.6	673.8	2,356.2	921.1	1,011.1
	Биелэлт	63.7%	28.3%	59.3%	38.2%	63.6%
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	Сан	1,144.4	1,407.4	2,100.2	2,263.5	3,167.2
	Зээлийн авлага	1,837.8	1,563.8	2,057.6	2,617.8	4,260.4

Эх сурвалж: Аудитын судалгаа



ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг удирдлага болгосон байна. Үүнд:

Нэг. Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын чиглэлээр

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

- Ирэх оны орон нутгийн төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд суурилах, үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхгүй байх, Сангийн яамны хянасан орлогын дүнтэй уялдуулах
- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60 хувийг улсын төсвийн орлого байхаар, мөн зүйлийн 23.6.10-т уг татварын 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх аж ахуй нэгжийн орлогын албан татварын хэмжээг хянасан дүнгээс нэмэгдүүлэхгүй байх.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг оны эхнээс жигд ханган ажиллах, татварын болон бусад өр төлбөр үүсгэхгүй байх
- Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгч, татвар төлөгчийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх, ажил гүйлгээг бүртгэлжүүлэх үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл эзэмшигчийн талаар мэдээллийг нэгтгэн бүртгэх, мэдээллийн сан байгуулах, уг сангийн мэдээллийг тогтмол баяжуулж, тус мэдээллийг харьяа татварын албатай хуваалцах
- Орон нутаг, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага болон татварын албаны хамтын ажиллагааг дэмжиж, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны хэмжээг үнэн зөв тогтоох, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх усны төлбөрийг бүрэн төвлөрүүлэх

Хоёр. Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагын чиглэлээр

1. Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарим ангиллыг шинэчлэн батлах тухай” журмыг мөрдөх
2. Цалин хөлс, орон тоо:
 - Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Засгийн газар агентлагийн бүтэц, орон тоог 9 хув, бууруулах арга хэмжээг 2025 оны төсвийн тодотголд тусгаж улсын хэмжээнд хэрэгжүүлсэн. Аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах.
3. Их засварын зардлын хуваарилалт
 - Их засварын зардлыг төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёл, спортын байгууллагын барилга, байгууламжийн их засварын хэрэгцээ шаардлагад үндэслэн хуваарилах бөгөөд, их засварын ажлыг гүйцэтгэхдээ барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, байгальд ээлтэй, нөхөн сэргээгдэх эрчим хүчний шинэ техник, технологи, хэрэглээг хянах ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэхэд түлхүү анхаарах.
4. Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээлийн талаар холбогдох чиглэлийг өгсөн байна.

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА

Баянхонгор аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.5-т заасны дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1а/1030 дугаар албан бичгээр ирүүлсэн.



Хүснэгт 8. Төсвийн тухай хуулийн шаардлага

№	Төсвийн тухай хуулийн заалт	Тусгасан эсэх
1	33.2.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого	Тийм
2	33.2.2.төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ	Тийм
3	33.2.4.бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг	Тийм
4	33.2.5.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар	Тийм
5	33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/	Тийм

Эх сурвалж: Төсвийн тухай хууль

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Баянхонгор аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төсөлд санхүүгийн дэмжлэг 28,056.7 сая, ОНХС-аас 21,974.4 сая, орон нутгийн суурь орлого 39,837.5 сая, нийт зардлыг 95,600.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцсон бөгөөд санхүүжилтийн зөрүүг уурхайн хандивын орлогоор нөхөхөөр тооцсон байна.

Аймгийн Засаг даргын 2026 оны төсвийн төсөлд аудит хийж дараах саналыг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлж байна.

НЭГ. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Орон нутгийн суурь орлого 39,837.5 сая төгрөгийг 1,761.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна.

Санал 1. Газрын дуудлага худалдааны орлогыг УИХ-аас баталсан суурь орлогод төлөвлөөгүй тул 140.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

Үндэслэл: Газрын дуудлага худалдааны орлогыг 2022 онд 200.0 сая төгрөг төлөвлөснөөс 315.2 сая төгрөг, 2023 оны 390.0 сая төгрөг төлөвлөснөөс 279.9 сая төгрөг, 2024 онд 123.1 сая төгрөг төлөвлөснөөс 149.2 сая төгрөг, 2025 онд 57.0 сая төгрөг төлөвлөснөөс 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 241.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 2026 онд 9 сумын 27 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулахаар төсөл ирүүлсэн УИХ-ын баталсан орлогыг төлөвлөгөөнд төлөвлөөгүй байна.

Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024, 2025 онд сумдын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г батлуулах ажил хийж байгаа тул газрын дуудлага худалдаа зохион байгуулах боломж бүрдэж байна.



Мөн Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө, ТЭЗҮ-д туссан худалдаа үйлчилгээний чиглэлээр газар олгох ажлыг зохион байгуулж дуудлага худалдааны орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Иймд газрын дуудлага худалдааны орлогыг сүүлийн 4 жилийн гүйцэтгэл, дээрх нөхцөл байдлыг үндэслэн 140.0 сая төгрөгөөр төлөвлөх.

Санал 2. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 115.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 621.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 736.0 сая төгрөг болгох

Үндэслэл: Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 10/41 дүгээр тогтоолоор Чандмань-Баянхонгор ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Хонгор-1000 дулаан үйлдвэрлэлийн барилга байгууламж”-ийг 10 жилийн хугацаатайгаар уралдаант шалгаруулалтаар хувьчилсан ба эргэн төлөлтийн хуваариар 2025 онд 203.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсөвт төвлөрүүлээгүй, 2026 онд 203.2 сая төгрөг төвлөрүүлэх хуваарьтай.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 13/13 дугаар тогтоолоор аймгийн Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зам талбайн хавтан үйлдвэрлэлийн иж бүрэн тоног төхөөрөмжийг 3 жилийн хугацаатайгаар уралдаант шалгаруулалтаар хувьчилсан ба эргэн төлөлтийн хуваариар 2025 онд 173.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсөвт төвлөрүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 9/18 дугаар тогтоолоор Байгаль орчин аялал, жуулчлалын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Виртуал студийн барилга, тоног төхөөрөмжийг 8 жилийн хугацаатайгаар уралдаант шалгаруулалтаар хувьчилсан ба 2025 онд 28.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төсөвт төвлөрүүлээгүй, 2026 онд 28.1 сая төгрөг төвлөрүүлэх хуваарьтай.

Аймгийн ОНӨГ нь 2024 онд нээлттэй дуудлага худалдаагаар 134.7 сая, 2025 онд нээлттэй дуудлага худалдаагаар 7 тээврийн хэрэгсэл худалдаж 31.3 сая, уралдаант шалгаруулалт болон нээлттэй дуудлага худалдаагаар 3 үл хөдлөх хөрөнгө хувьчилж 48.1 сая төгрөг нийт 79.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба 2026 онд төсвийн төлөвлөгөөнд тусгагдаагүй тул нэмж тусгах шаардлагатай.

Мөн орон нутгийн өмчид бүртгэлтэй актлагдсан объектыг дуудлага худалдаанд оруулж орлогоо нэмэгдүүлэх боломж байна.

Иймд 2026 онд нээлттэй дуудлага худалдаа, уралдаант шалгаруулалтаас 100.0 сая, гэрээний эргэн төлөлтөөс 636.0 сая төгрөг төвлөрүүлэх боломжтой тул Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 736.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.

Санал 3. Ан амьтны нөөц ашигласны орлогыг 530.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,530.0 сая төгрөг болгох.

Үндэслэл: Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод бага хэмжээгээр төлөвлөж, давуулан биелүүлсэн орлогыг сумдын



ИТХ-аар тодотгон зарцуулж байгаа нь төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах нөхцөл бүрдэж байна.

Орон нутгийн төсвийн орлогод ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2022 онд 4,456.5 сая, 2023 онд 3,544.1 сая, 2024 онд 3,208.2 сая төгрөг төвлөрсөн байна.

Сүүлийн 3 жилийн дундаж орлого 3,736.2 сая төгрөг байгаа бөгөөд 2025 онд 2,090.2 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 2025 оны 10 дугаар сарын байдлаар 2,569.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Иймд өмнөх онуудын гүйцэтгэлтэй уялдуулан 2026 оны төсвийн төсөлд Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөснөөр гэнэтийн орлогыг үр ашиггүй зүйлд тодотгон зарцуулдаг байдлыг таслан зогсоож, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу үр ашигтай зарцуулах боломж бүрдэнэ.

ХОЁР. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛЖ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ 11,583.6 САЯ ТӨГРӨГИЙН САНАЛ

Санал 1: Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр аймаг, сумын Засаг даргын орлогч нарт чөлөөлөгдсөний мөнгөн тэтгэмжийн зардлыг 172.3 сая төгрөгөөр бууруулах.

Үндэслэл: Аймгийн 2026 оны төсвийн төсөлд Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн аймаг, сумдын Засаг даргын орлогч нарт “Сонгуулийн үр дүнд албан тушаалаас чөлөөлөгдвөл тэтгэмж” 172.3 сая төгрөг олгохоор төлөвлөсөн нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Иймд Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн аймгийн болон 12 сумын Засаг даргын орлогч нарт олгохоор төлөвлөсөн 172.3 сая төгрөгийн тэтгэмжийн зардлыг бууруулах саналтай байна.

Санал 2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 1,767.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 767.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээг тухайн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэн төсвийн үр ашгийг сайжруулах.

Үндэслэл: Аймгийн ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалтаар Баянговь суманд баригдаж байгаа спорт заалны барилгын санхүүжилт 150.0 сая, Баян-Өндөр суманд мах нядалгааны цэг, зоорь байгуулах ажлын 1,617.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 617.8 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг тухайн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бололцоотой байна.

Тухайлбал: Аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн суурь тооцооллоор Баянговь сумд 1,327.9 сая, Баян-Өндөр



сумд 1,518.1 сая төгрөг хуваарилж байгаа бөгөөд энэ нь аймгийн сумдад олгох орлогын шилжүүлгийн дунджаас Баянговь сумд 565.5 сая, Баян-Өндөр сумд 755.7 сая төгрөгөөр илүү олгохоор байна.

Иймд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад багтсан дээрх 2 ТАХ-г сумын ОНХС-аар хэрэгжүүлэх боломжтой тул 767.8 сая төгрөгийн төсвийн үр ашгийг сайжруулахыг санал болгож байна.

Санал 3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 350.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй арга хэмжээний үр ашгийг сайжруулах.

Үндэслэл: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Шаардлагатай сумдын хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах” (7 сум) хийх ажлыг 900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2026 онд 350.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Өмнөх онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр сумдад “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” хийхээр 500.0 сая төгрөг, сумдын ОНХС-аас 50.0-150.0 сая төгрөг баталж 9 сум, Шинэжинст, Баянцагаан сумд сумын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна.

Өмнөх жилүүдэд сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж “Түмэд групп” ХХК-иар хийлгэсэн “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г аймгийн ИТХ-аар хэлэлцэн батлаагүй, магадлалаар баталгаажуулаагүйгээс тус төлөвлөгөөг ашиглаагүй, хөрөнгийн үр ашиг гараагүй байна.

Иймд сумдын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” хийх төсөл, арга хэмжээний үр дүнг гаргаж төсвийн үр ашгийг сайжруулахыг санал болгож байна.

Санал 4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 410.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй арга хэмжээг тооцоолол судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл байхгүй тул төсөвлөлтийн шаардлага хангасан үр ашигтай төсөл арга хэмжээнд төлөвлөх.

Үндэслэл: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Баянхонгор сумын гэр хорооллын дэд бүтцийн ажлыг үргэлжлүүлэх” ажлыг 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 410.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан боловч зураг төсөл болон урьдчилан тооцоолол байхгүй төсөвлөлтийн шаардлага хангаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчиж байна. Энэ нь цаашид төсөв хүрэлцэхгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна.

Иймд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад багтсан дээрх ажлыг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴ дэх заалтад нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



Цаашид УТХО-аар хийсэн Баянхонгор сумын гэр хорооллын дэд бүтцийн ажлын үр ашгийг төлөвлөсөн хэмжээнд бүрэн гаргаж ашиглалтыг сайжруулах шаардлагатай.

Санал 5. Орон нутгийн төсвөөс 2026 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад шинээр хэрэгжүүлэх Шүүхийн шинжилгээний хэлтсийн байрны засварын ажлыг 50.0 сая төгрөгөөр тусгасныг өөрчилж төсвийн үр ашгийг сайжруулах.

Үндэслэл: Засварын ажлын төсөвт дүн шинжилгээ хийхэд Шүүхийн шинжилгээний байрны засварын ажлыг 50.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6⁵-д заасан төсвийн зарчим, “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-д заасны дагуу боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёл, спортын байгууллагын барилга, байгууламжийн их засварт төлөвлөх гэсэн чиглэлтэй нийцэхгүй байна.

Иймд аймгийн барилга, байгууламжийн их засварын жагсаалтад 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан Шүүхийн шинжилгээний байрны засварын ажлын 50.0 сая төгрөгийн хөрөнгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Сангийн яамнаас ирүүлсэн “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-д нийцүүлэн үр ашигтай төлөвлөж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхийг санал болгож байна.

Санал 6. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийж УИХ-аас баталсан аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах.

Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Засгийн газар агентлагийн бүтэц, орон тоог 9 хувиар бууруулахаар тогтоосон бөгөөд 2026 оны төсвийн төсөлд 746 орон тоо төлөвлөсөн байна.

Үүний дагуу Баянхонгор аймгийн зарим сумдын ЗДТГ-ын биеийн тамирын арга зүйч, гэрээт харуул, архив, бичиг хэргийн эрхлэгч зэрэг орон тоог цомхотгосон хэдий ч судалгаагаар 2025 оны 10 дугаар сард 824 орон тоотой ажиллаж байна. Иймд Засгийн газрын чиглэлийг хэрэгжүүлэн цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах.

Санал 7. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах цаглавар” хугацаанд аймгийн ИТХ-аар хэлэлцэн батлах ажлыг зохион байгуулах

Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 3 дугаар хавсралтын “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах

⁵ тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.;



цаглавар”-т заасан хугацаанд аймгийн ЗДТГ нь нөхцөл байдлын дүн шинжилгээ хийгээгүй, төлөвлөгөөний төслийг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцээгүй, 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг заасан хугацаанд аймгийн ИТХ-д хүргүүлээгүй байна.

Иймд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах цаглавар”-ыг мөрдөж ажиллаж байх.

Санал 8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан 9,833.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх.

Үндэслэл: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан 2,527.7 сая төгрөгийн өртөг бүхий ингэний сүүний үйлдвэр, 1,911.3 сая төгрөгийн өртөг бүхий өвлийн хүлэмж, 4,074.0 сая төгрөгийн мах ногооны зоорь ашиглалтгүй байна.

Иймд дээрх хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон үйлдвэрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эсвэл уралдаант сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа зохион байгуулах замаар хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх боломж байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

1. Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 1,761.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, суурь зарлага бууруулах, төсвийн үр ашгийг 11.583.6 сая төгрөгөөр дээшлүүлэх нийт 13,344.6 сая төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлж байна.
2. Аймгийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг төлөвлөхдөө төр хувийн хэвшлийн түншлэл, санхүүгийн нөөц боломжийг бүрэн тусгаагүй зөвхөн төсвийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тооцсон байна.
3. Орон нутгийн хөгжлийн зорилтыг хангах зорилгоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглал, хадгалалт, хамгаалалт, төслийн хэрэгжилтэд явцыг хянах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан төсвийн үр ашиг төлөвлөсөн хугацаандаа үр өгөөжөө өгөхгүй байх, үргүй зардал болж байна.
4. Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах цаглавар”-т заасан хугацаанд аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцээгүй, 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг аймгийн ИТХ-д хүргүүлээгүй байна.

АЙМГИЙН ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ:

Нэг. Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 3 дугаар хавсралтын “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах цаглавар”-т заасан хугацаанд өргөн мэдүүлсэн хөгжлийн төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-т хугацаанд хэлэлцэн батлах нь зүйтэй байна.

Хоёр. Уул уурхайн томоохон төслөөс орон нутгийн хүртэх үр өгөөж, орлого нэмэгдэх төлөв ажиглагдаж байгаа тул аймгийн хөгжлийн бодлогыг үүнтэй уялдуулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Нэг. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Мөнхсайхан танаа

- ✓ Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийж УИХ-аас баталсан аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах.
- ✓ Аймгийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг төлөвлөхдөө төр хувийн хэвшлийн түншлэл, санхүүгийн нөөц боломжийг бүрэн тусгах боломжийг судлах.
- ✓ Хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах шат бүрийг холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлэх

ХАВСРАЛТ

Хавсралт 01 -ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Хавсралт 02-ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛЖ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ



ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

(сая төгрөг)

№	Татварын болон татварын бус орлого	Мөнгөн дүн
1	Газрын дуудлага худалдааны орлогыг УИХ-аас баталсан суурь орлогод төлөвлөөгүй тул 140.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх	140.0
2	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 115.0 сая төгрөгөөр төлөвлөснийг 621.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 736.0 сая төгрөг болгох	621.0
3	Ан амьтны нөөц ашигласны орлогыг 530.0 саяГ төгрөгөөр төлөвлөснийг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,530.0 сая төгрөг болгох	1,000.0
	Орон нутгийн орлого нэмэгдүүлэх нийт дүн	1,761.0

оОо



ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛЖ, ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

(сая төгрөг)

№	Утга	Мөнгөн дүн
1	Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр аймаг, сумын Засаг даргын орлогч нарт чөлөөлөгдсөний мөнгөн тэтгэмжийн зардлыг 172.3 сая төгрөгөөр бууруулах	172.3
2	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 1,767.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 767.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг тухайн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэн төсвийн үр ашгийг сайжруулах	767.8
3	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 350.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй арга хэмжээний үр ашгийг сайжруулах	350.0
4	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 410.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй арга хэмжээг тооцоолол судалгаа, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл байхгүй тул төсөвлөлтийн шаардлага хангасан үр ашигтай төсөл арга хэмжээнд төлөвлөх	410.0
5	Орон нутгийн төсвөөс 2026 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад шинээр хэрэгжүүлэх Шүүхийн шинжилгээний хэлтсийн байрны засварын ажлыг 50.0 сая төгрөгөөр тусгасныг өөрчилж төсвийн үр ашгийг сайжруулах	50.0
6	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийгдэж байнгын ашиглалтад хүлээн авсан 9,833.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх	9,833.5
	Нийт дүн	11,583.6